



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

АРХАНГАЙ АЙМГИЙН
АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ШИНЭ НАМД

2024.08.08 № 341

танай _____ -ны № _____ -т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, 37.10, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4 дэх хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024оны Архангай аймгийн аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох "Шинэ нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийнхүрээний

мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

“Шинэ нам”-ын Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Шинэ нам”-ын мөрийн хөтөлбөр (..... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: “Архангай аймгийн сонгуулийн хороо”-нд

Хавсралт хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



“ШИНЭ СОНГОЛТ-ШИНЭ МОНГОЛ”

*Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ийн
хурлын сонгуулийн
мөрийн хөтөлбөр - 2024*

/АРХАНГАЙ АЙМАГ/

Улаанбаатар хот 2024 он

ГАРЧИГ

1. НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁСНЫ ЗАРЧМЫГ БЭХЖҮҮЛНЭ
2. БАЯЛАГИЙН ӨГӨӨЖИЙГ МОНГОЛ ХҮН ХҮРТЭНЭ
3. АЖ ҮЙЛДВЭРИЙН ХУВЬСГАЛ
4. МАЛ АЖ АХУЙ- ГАЗАР ТАРИАЛАН
5. БУСЧИЛСЭН ХӨГЖИЛ-АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ
6. МОНГОЛ ТӨРИЙН ҮНДЭС – ХҮЧИРХЭГ МОНГОЛ ГЭР БҮЛ
7. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ
8. ҮНДЭСНИЙ ЭРХ АШИГ, ОЮУН САНААНЫ СЭРГЭЛТ
9. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

6517140983
А-040052 9001004



УДИРДТГАЛ

Улс эх орон эзэнтэй байх тулгуур үндэс нь ард иргэдийн ахуй амьдралын таатай орчин хэр зэрэг бурдсэн байна, таатай амьдрах нөхцөл бүрдүүлэх эдийн засгийн боломж бололцоог төр засгаас хэрхэн хангаж байгаа байдал нь шийдвэрлэх ач холбогдолтой байсаар ирсэн.

Улс орны хөгжил гэдэг нь улстөрийн талцал хуваагдал, орон нутгийн явцуу эрх ашгаас илүүтэйгээр үндэсний эрх ашгийг дээгүүр тавьж, нутаг дэвсгэрийн төлөвлөлт, хөгжлийн асуудлыг цогцоор авч үзэн бус нутаг бүрийн нөөц, чадавхыг нийтлэг эрх ашгийн төлөө оновчтой ашиглах, аймаг, нийслэл, сум, хорооны хоорондын харилцан хамаарал, хамтын ажиллагааны механизмыг үр дүнтэй ашиглах, байгалийн баялагийг үр шим, өгөөжийг бодитоор хүртдэг болох нь хүн амын шилжилт хөдөлгөөний эерэг, сөрөг үр дагавртай шууд хамаарлтай.

Үндсэн хуулийн 3.1 "Засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна" гэсэн зарчмыг аймаг, нийслэл, орон нутгийн хэмжээнд бүрэн хэрэгжүүлж цомхон, хязгаарлагдмал, хариуцлагатай, арчилсан, нийгэмд тэгш үйлчилдэг засаглалыг бий болгож иргэд нь өөрсдөө хийж чадах ажлыг орон нутгийн түвшинд өөрсдөө шийддэг, аймаг, нийслэл, сум хорооны хөгжлийг төр засгийн хязгаарлагдмал оролцоотойгоор хэрэгжүүлнэ.

Орон нутгийн хэмжээнд улстөрийн намын бүтэц ажиллахыг хязгаарлан, төрийн алба, ард иргэд нь намаар талцдаг байдлыг зогсоож, авлигыг устган, сум хороондоо сайхан амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

Сум хороонд эдийн засгийн эрх чөлөөг олгосноор арилжаа худалдаа, аялал жуулчлал, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хөгжил цэцэглэх, орон нутгийн бүтээн байгуулалтад нутгийн иргэд, ААН давуу байдалтай оролцдог байх боломжийг нээж өгснөөр орон нутаг эзэнтэй байх нөхцлийг бүрдүүлнэ. Эдгээр зорилгыг хэрэгжүүлэхийн тулд 2024 оны аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн хурлын төлөөлөгчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг дэвшүүлж байна.



1. НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁСНЫ ЗАРЧМЫГ БЭХЖҮҮЛНЭ

Хүний жам ёсны эрх болсон амьд явах, эрх чөлөөтэй байх, өмчлөх эрхийг эрхэмлэн дээдэлсэн, иргэдийн оролцоотой, цомхон, хяналттай, хариуцлагатай нутгийн өөрөө удиরдах ёсны зарчмыг бэхжүүлнэ. Орон нутгийн чанартай аливаа ажлыг нутгийн иргэдийн санал, шийдвэрийн дагуу өөрсдөө хийж чадах бүхнийг нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүд гүйцэтгэн хийдэг байх эрх мэдлийг олгоно.

2. БАЯЛАГИЙН ӨГӨӨЖИЙГ МОНГОЛ ХҮН ХҮРТЭНЭ

Стратегийн ордод тооцогдоноос бусад орон нутгийн чанартай эрдэс түүхий эд, байгалийн баялаг, ордыг ашиглах, олборлох. бусдад ашиглуулах эрхийг тухайн орон нутгийн иргэдийн олонхийн саналаар шийдвэрлэж байх эрх мэдлийг орон нутгийн иргэдэд олгоно.

3. АЖ ҮЙЛДВЭРИЙН ХУВЬСГАЛ

Байгалийн баялаг, эрдэс түүхий эд, мал, малын гаралтай бүтээгдэхүүн, тэдгээрийн боловсруулалт, үйлдвэрлэл, газар тариалан, эрдэм мэдлэг, оюун ухаанд суурилсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл үйлчилгээнд төрөөс үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлж, хиймэл оюун ухаан, техник технологийн дэвшил ашигласан, орон нутагт ажлын байр, ажилчдын цалин хөлс нэмэгдүүлэх, иргэдийн шилжилт хөдөлгөөнийг сааруулсан аж үйлдвэржилтийг бүхий л талаараа дэмжинэ.

4. МАЛ АЖ АХУЙ- ГАЗАР ТАРИАЛАН

Мал аж ахуйн талаар төрөөс баримтлах бодлогыг дэмжин ажиллах, малын гаралтай бүтээгдэхүүн болох мах, сүү, цагаан идээ боловсруулах нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, газар тариаланг хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай услагааны системийг нэмэгдүүлнэ.

5. БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ-АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Монгол улсын түүх, соёл, үндэсний өв уламжлал, нүүдэлчин ахуйн ёс заншил, байгалийн үзэсгэлэнт газруудыг гадаад дотоодын жуулчдад таниулах, дөрвөн улирлын аялал жуулчлалыг Алтайн бүс, баруун бүс, хангайн бүс, төвийн бүсийн онцлогт тохируулан хөгжүүлэхэд бүс хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулна.

6. МОНГОЛ ТӨРИЙН ҮНДЭС – ХҮЧИРХЭГ МОНГОЛ ГЭР БҮЛ

Төр улсын үндэс - монгол өрх, гэр бүлийг ирээдүйдээ итгэлтэй, амар амгалан амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор иргэн бүрийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын чанартай, хүртээмжтэй үйлчилгээнд хамруулна. Хүүхэд бүрт чанартай, тэгш, хүртээмжтэй боловсролыг олгохын тулд багш нарын чадавх, цалин хангамжийг сайжруулан “Хамгийн сайн сургууль бол гэртээ хамгийн ойр сургууль” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

7. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэмд эзлэх байр суурийг нэмэгдүүлэх, тэдэнд үзүүлэх нийгэм, эрүүл мэндийн үйлчилгээг сайжрууна

8. ҮНДЭСНИЙ ЭРХ АШИГ, ОЮУН САНАААНЫ СЭРГЭЛТ

Үндэсний өв уламжлал, ёс заншил, түүхэнд шингэсэн мэдлэгээ хүүхэд залуус, хойч үедээ өвлүүлэн үлдээж, иргэн бүрт эх орон, газар шороо, тусгаар тогтолц, Үндэсний аюулгүй байдал, иргэдийн заяагдмал эрхийг хамгаалсанбодлого



хэрэгжүүлж, их түүх, соёлын өв, үндэсний үнэт зүйлээ хамгаалах хууль эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.

9. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Мөрийн хөтөлбөрт 21 аймаг, орон нутгийн бүсчилсэн хөгжлийн чиглэлээр тусгайлан орох заалтуудыг тусгав.

1. НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁСНЫ ЗАРЧМЫГ БЭХЖҮҮЛНЭ

Хүний жам ёсны эрх болсон амьд явах, эрх чөлөөтэй байх, өмчлөх эрхийг эрхэмлэн дээдэлсэн, иргэдийн оролцоотой, цомхон, хяналттай, хариуцлагатай нутгийн өөрөө удиরдах ёсны зарчмыг бэхжүүлнэ. Орон нутгийн чанартай аливаа ажлыг нутгийн иргэдийн санал, шийдвэрийн дагуу өөрсдөө хийж чадах бүхнийг нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүд гүйцэтгэн хийдэг байх эрх мэдлийг олгоно.

- 1.1 Хүний жам ёсны эрх болсон амьд явах, эрх чөлөөтэй байх, өмчлөх эрхийг эрхэмлэн дээдэлнэ.
- 1.2 Хувь хүний амьд явах суурь нөхцөл болсон эрх чөлөө ба өмчлөх эрхэнд хууль бусар халдахыг зогсоно. Өмчийг зөвхөн нийтийн сайн сайхны төлөө төлбөртэйгөөс бусад нөхцөлөөр хураан авахыг хориглосон эрх зүйн орчин бүрдүүлнэ.
- 1.3 Орон нутгийн чанартай ажлыг иргэдээс санал авсаны үндсэн дээр ямар ажлыг, ямар төсөв хөрөнгөөр, ямар аж ахийн нэгж, иргэнээр гүйцэтгүүлэхийг шийдвэрлэдэг байх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- 1.4 Орон нутгийн чанартай ажлыг иргэдээс санал авсаны үндсэн дээр гүйцэтгэнээр орон нутгийн аж ахий нэгжүүд ажилтай, иргэд нь орлоготой, иргэдийн шилжилт хөдөлгөөн багасна.
- 1.5 Шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлж цомхон, хяналттай, эдийн засгийн хэмнэлтэй ажиллах нөхцөл бүрдүүлнэ.

2.БАЯЛАГИЙН ӨГӨӨЖИЙГ МОНГОЛ ХҮН ХҮРТЭНЭ

Стратегийн ордод тооцогдоноос бусад орон нутгийн чанартай эрдэс түүхий эд, байгалийн баялаг, ордыг ашиглах, олборлох, бусад ашиглуулах эрхийг тухайн орон нутгийн иргэдийн олонхийн саналаар шийдвэрлэж байх эрх мэдлийг орон нутгийн иргэдэд олгоно.

- 2.1 Орон нутгийн чанартай эрдэс түүхий эд, байгалийн баялаг, ордыг ашиглах, олборлох, хэрхэн ашиглах эрхийг тухайн орон нутгийн иргэд шийдвэрлэнэ
- 2.2 Орон нутгийн чанартай эрдэс түүхий эд, байгалийн баялаг, ордыг ашиглах, олборлох үйл ажиллагааг хэнээр гүйцэтгүүлэхээ нутгийн иргэд шийдвэрлэдэг болох эрхзүйн орчныг бүрдүүлнэ
- 2.3 Орон нутгийн чанартай эрдэс түүхий эд, байгалийн баялаг, ордыг ашиглаж, олборлосноос гарах өгөөжийг тухайн орон нутгийн иргэд хүртдэг болох эрхзүйн орчныг бүрдүүлнэ
- 2.4 Нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлд тавих иргэдийн хяналтыг сайжруулна



- 2.5 Орон нутгийн чанартай ордыг ашиглах компани нээлттэй, олон нийтийн компани байж иргэд нь тухайн компанийн хувьцаа эзэмшигч буюу хөрөнгө оруулагч байна.
- 2.6 Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг нэмэгдүүлж, экспортлож байгаа бүтээгдэхүүнд тавих хяналтыг эрс сайжруулна

3. АЖ ҮЙЛДВЭРИЙН ХУВЬСГАЛ

Байгалийн баялаг, эрдэс түүхий эд, мал, малын гаралтай бүтээгдэхүүн, тэдгээрийн боловсруулалт, үйлдвэрлэл, газар тариалан, эрдэм мэдлэг, оюун ухаанд суурилсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл үйлчилгээнд төрөөс үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлж, хиймэл оюун ухаан, техник технологийн дэвшил ашигласан, орон нутагт ажлын байр, ажилчдын цалин хөлс нэмэгдүүлэх, иргэдийн шилжилт хөдөлгөөнийг сааруулсан аж үйлдвэржилтийг бүхий л талаараа дэмжинэ.

- 3.1. Байлагийн баялаг, эрдэс түүхий эдийг боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх бүтээлч санаачлагийг дэмжинэ
- 3.2. Мал, малын гаралтай бүтээгдэхүүн, тэдгээрийн боловсруулалт, үйлдвэрлэлт, чанарыг сайжруулж, гадаад дотоодын зах зээлд гарах боломжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 3.3. Мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн санхүүжилт, хүнсний нөөц түүхий эдийн баталгаат агуулахын нэгдмэл тогтолцоог бий болгоно
- 3.4. Хүнд аж үйлдвэр, хүнс, хөдөө аж ахуй, барилгын материал, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлж, АНУ, ХБНГУ, БНСУ, Япон улс зэрэг улсын технологи, евро стандартыг нутагшуулах эрхзүйн орчныг бүрдүүлнэ
- 3.5. Байгаль орчинд ээлтэй, эрчим хүчиний хэмнэлттэй, ухаалаг тээвэр, ложистик, үйлдвэрлэлийг дэмжинэ.
- 3.6. Орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг нээлттэй хувьцаат компани болохыг дэмжих бодлого баримтална.
- 3.7. Үндэсний брэндийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хоршиж ажиллах (кластер) тогтолцоог бий болгоно.
- 3.8. Хүнсний үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, хүнсний суурь хэрэгцээг дотоодоосоо хангах боломжийг бизнес эрхлэгчдэд нээж, органик, эко хүнсний экспортыг нэмэгдүүлнэ.
- 3.9. Технологи, инновацийг хөгжүүлж, шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг оновчтой болгоно.

4. МАЛ АЖ АХУЙ- ГАЗАР ТАРИАЛАН

Мал аж ахуйн талаар төрөөс баримтлах бодлогыг дэмжин ажиллах, малын гаралтай бүтээгдэхүүн болох мах, сүү, цагаан идээ боловсруулах нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, газар тариаланг хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай улагааны системийг нэмэгдүүлнэ.



- 4.1 Арьс шир, ноос, ноолуур, дайвар бүтээгдэхүүний боловсруулалтыг 70-аас доошгүй хувьд хүргэх, үнэ цэнийг нэмэгдүүлэх бодлогыг баримтална.
- 4.2 Мал сүргийн тоо, төрлийн зохистой харьцааг бүрдүүлэх, бэлчээр хамгаалахад чиглэсэн малын хөлийн татварын шаталсан, ялгавартай татвар тогтоох эрхийг орон нутгийн иргэд, иргэдийн хуралд өгнө.
- 4.3 Мал эмнэлгийн олон улсын жишигт нийцсэн үндэсний тогтолцоог бий болгох, малын эрүүл мэнд, удмын санг сайжруулах бодлогыг баримтална.
- 4.4 Малчдын орлогын эх үүсвэрийг тодорхой болгож малчин өрх бүр үйлдвэрлэл эрхлэх боломж олгоно.
- 4.5 Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон мал аж ахуй, бэлчээр ашиглалтын бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
- 4.6 Max, махан бүтээгдэхүүний экспортыг төрөөс нэгдсэн бодлогоор зохицуулж зөвхөн дотоодын зах зээлийг хангасны дараа экспортлох бодлогыг хэрэгжүүлнэ.
- 4.7 Нарийн, нарийн ноост хонь, мах, сүүний чиглэлийн үхэр гэх мэт өндөр ашиг, шимт мал сүргийн бүтцийг хөгжүүлж, монгол орны уур амьсгалд зохицсон үүлдрийг нутагшуулах бодлого баримтална.
- 4.8 Газар тариаланг хөгжүүлэх зорилгоор усалгааны систем барьж усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ
- 4.9 Хүн амын хэрэгцээг эрүүл баталгаатай хүнсээр хангах дотоодын хэрэгцээнд нийлүүлж байгаа махны 50 хувь, сүүний 60 хүртэл хувийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулдаг болно.
- 4.10 Генийн өөрчлөлттэй бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импортыг үе шаттайгаар хориглон экологийн цэвэр, эрүүл хүнсний хэрэглээг дэмжинэ.
- 4.11 Хүнсний гол нэрийн төрлийн бүтээгдэхүүний найдвартай хангамжийг тогтмол нэмэгдүүлнэ. Баталгаат хүнсний аюулгүйн нөөцийн улсын болон бус нутгийн агуулахын систем байгуулахыг дэмжинэ.

5.БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ-АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Монгол улсын түүх, соёл, үндэсний өв уламжлал, нүүдэлчин ахуйн ёс заншил, байгалийн үзэсгэлэнт газруудыг гадаад дотоодын жуулчдад таниулах, дөрвөн улирлын аялал жуулчлалыг Алтайн бус, баруун бус, хангайн бус, төвийн бүсийн онцлогт тохируулан хөгжүүлэхэд бус хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулана.

- 5.1. Монгол улсын түүх, соёл, үндэсний өв уламжлал, нүүдэлчин ахуйн ёс заншилд тулгуурласан аялал жуулчлалыг хөгжүүлнэ



- 5.2. "Монголдоо аялцгаая" хөдөлгөөнийг Алтайн бүс, баруун бүс, хангайн бүс, төвийн бүсийн онцлогт тохируулан өрнүүлнэ
- 5.3. Аялал жуулчлалыг дөрвөн улирлын онцлогт тохируулан хөгжүүлэх бодлого баримтална
- 5.4. Гадаад дотоодын аялал жуулчлалыг нутгийн иргэдийн ахуй амьдрал, нүүдэлчин соёлыг таниулах жуулчлалыг хөгжүүлнэ

6. МОНГОЛ ТӨРИЙН ҮНДЭС – ХҮЧИРХЭГ МОНГОЛ ГЭР БҮЛ

Төр улсын үндэс - монгол өрх, гэр бүлийг ирээдүйдээ итгэлтэй, амар амгалан амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор иргэн бүрийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын чанартай, хүртээмжтэй үйлчилгээнд хамруулна. Хүүхэд бүрт чанартай, тэгш, хүртээмжтэй боловсролыг олгохын тулд багш нарын чадавх, цалин хангамжийг сайжруулан "Хамгийн сайн сургууль бол гэртээ хамгийн ойр сургууль" хөтөлбөр хэрэгжүүлнэ.

- 6.1. Хүүхдийг сургуулийн орчинд хамгаалах зорилгоор сургууль бүрийн дэргэд багш, сурган хүмүүжүүлэгчээс гадна сургуулийн цагдаа, эмч, сэтгэл зүйч, хоол зүйч, эцэг, эхийн хороог байгуулж хүүхдийг бүх талаар хамгаалах бодлогыг дэмжинэ.
- 6.2. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын чанарыг сайжруулж сургалтын нэг стандартаар суралцах боломжийг хангана
- 6.3. Ирээдүйн иргэдийг төлөвшүүлж сургаж байгаа багш нарын цалин хангамжийг нэмэгдүүлэх боломжийг бий болгон
- 6.4. "Хамгийн сайн сургууль бол гэртээ хамгийн ойр сургууль" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 6.5. Гэр бүлийн бодлогыг шинэчлэх замаар гэр бүлийн эрүүл мэнд, боловсрол, эмэгтэйчүүд, залуучууд, ахмадын асуудлыг цогцоор нь шийдвэрлэнэ.
- 6.6. Нийгмийн хамгааллын үйлчилгээг ядуу, эмзэг бүлгүүдэд оновчтой, эрх тэгш хүртээх бодлогыг баримтална.

7. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэмд эзлэх байр суурийг нэмэгдүүлэх, тэдэнд үзүүлэх нийгэм, эрүүл мэндийн үйлчилгээг сайжрууна

- 7.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж ахуй эрхлэх, сурч боловсрох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.
- 7.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх боломж нөхцөлөөр хангах бодлого баримтална.
- 7.3. Нийтийн тээврийн үйлчилгээнд явж буй автобус, төрийн болон олон нийтийн байгууллагуудын орц, гарцыг ХБИ-д ээлтэй байх боломжийг нэмэгдүүлнэ
- 7.4. ХБИ-ийн эрүүл мэндийн үйлчилгээг харьялал харгалзахгүй болгоно.
- 7.5. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчидтай ажиллах багш нарыг дэмжиж бэлтгэнэ.



8. ҮНДЭСНИЙ ЭРХ АШИГ, ОЮУН САНААНЫ СЭРГЭЛТ

Үндэсний өв уламжлал, ёс заншил, түүхэнд шингэсэн мэдлэгээ хүүхэд залуус, хойч үедээ өвлүүлэн үлдээж, иргэн бүрт эх орон, газар шороо, тусгаар тогтнол, Үндэсний аюулгүй байдал, иргэдийн заяагдмал эрхийг хамгаалсан бодлого хэрэгжүүлж, их түүх, соёлын өв, үндэсний үнэт зүйлээ хамгаалах хууль эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.

- 8.1. Сурах бичгийг үндэсний аюулгүй байдлын бодлогын түвшинд боловсруулж, Үндэсний өв уламжлал, ёс заншлыг хүүхэд залуучуудад таниулна
- 8.2. Хүүхэд залуус, иргэн бүрт эх орон, газар шороо, тусгаар тогтнол, Үндэсний аюулгүй байдал ач холбогдлыг ойлгуулах соён гэгээрүүлэх ажлыг дэмжинэ
- 8.3. Иргэдийн заяагдмал эрх болох үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, амьдран суух газраа чөлөөтэй сонгох эрхийг хамгаална

ЁС. АРХАНГАЙ

1. Боловсруулах үйлдвэр бүхий МАА-н үйлдвэрлэлийн кластерийг хөгжүүлэх
АЮДА0052 3001034
2. Боловсруулах үйлдвэр хөгжүүлэх зорилгоор сонгогдсон хотуудын дэд бүтцийг сайжруулах
3. МАА-н кластерийг сайжруулах зорилгоор малын үйлдвэрлэлийг дэмжих
4. Цэцэрлэг хотыг түшиглэсэн байгалийн аялал жуулчлал, өвлийн амралт зугаалгын газрыг хөгжүүлэх
5. Малчдад зориулсан зайнаас эмнэл зүйн зөвлөгөө өгөх, алсын зайны сургалт зохион байгуулах, цаг уурын урьдчилсан мэдээлэл өгөх, МАА-н кластерийг дэмжих, харилцаа холбооны технологийг өргөн нэвтрүүлэх





“ШИНЭ СОНГОЛТ-ШИНЭ СУМ”

**Эрдэнэбулган сумын ИТХ-ийн хурлын
сонгуулийн мөрийн хөтөлбөр - 2024**

ГАРЧИГ

1. “Цэвэр цэмцгэр цэцэрлэг хот” хөтөлбөрийг хэрэгжүүлж иргэдийн амьдрах орчин нөхцлийг сайжруулна.
2. Аж үйлдвэр, хөдөө аж ахуй, мал аж ахуй.
3. Аялал жуулчлал
4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах.
5. Ниймийн чиглэлд баримтлах бодлого.



**1.“Цэвэр цэмцгэр, аюулгүй цэцэрлэг “ хот хөтөлбөрийг хэрэгжүүлж,
иргэдийн амьдрах орчин нөхцлийг сайжруулна.**

- 1.1 Эрдэнэбулган сумын зам, гудамж талбайн тохижилт, засвар арчилгааг сайжруулна.
- 1.2 Сумын төв дахь харанхуй бүс газаруудад гэрэл гэрэлтүүлгийг нэмж сайжруулна.
- 1.3 Эрдэнэбулган сумын хэмжээнд хогны менежмент хийж, хоггүй байлгах арга хэмжээ авч ажиллана.
- 1.4 Сумын төвийн гол горхи дагуу тохижилт хийж, цэцэрлэг ногоон байгууламжийн тоог нэмэгдүүлнэ.
- 1.5 Сумын төвийн замын тэмдэг тэмдэгээ, гарц, гэрлэн дохиог сайжруулна.

2. Аж үйлдвэр, хөдөө аж ахуй, мал аж ахуй.

- 2.1 Үйлдвэрлэл эрхлэгчид болон жижиг дунд үйлдвэрлэгчдэд бодлогын дэмжлэг үзүүлнэ.
- 2.2 Өрхийн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж, ажлын байр нэмэгдүүлэх бодлогыг баримтална.
- 2.3 Малаас гарах түүхий эдийг эцсийн бүтээгдэхүүн болгоход малчид болон үйлдвэрлэгчидтэй хамтарч ажиллана
- 2.4 Малын эрүүл мэндийн тогтолцоог сайжруулан, бэлчээрийн менежметийг зөв төлөвлөж ажиллана.
- 2.5 Төмс хүнсний ногооны тариалалтыг бодлогоор дэмжин дотоодын зах зээлээ хангах тогтолцоог бололвсруулна.
- 2.6 Малчдад зориулсан зайнаас эмнэл зүйн зөвлөгөө өгөх, алсын зайны сургалт зохион байгуулах, цаг уурын урьдчилсан мэдээлэл өгөх, МАА-н кластерийг дэмжих, харилцаа холбооны технологийг өргөн нэвтрүүлэх

3. Аялал жуулчлал дотоодын төвшинд хөгжүүлнэ.

- 3.1 Аялал жуулчлалыг дөрвөн улирлын онцлогт тохируулан хөгжүүлэх бодлого баримтална.
- 3.2 Гадаад дотоодын аялал жуулчлалыг нутгийн иргэдийн ахуй амьдрал, нүүдэлчин соёлыг таниулах жуулчлалыг хөгжүүлнэ
- 3.3 Монгол улсын түүх, соёл, үндэсний өв уламжлал, нүүдэлчин ахуйн ёс заншилд тулгуурласан аялал жуулчлалыг хөгжүүлнэ
- 3.4 Гадаадын жуулчид аялан саатах орчин нөхцлийг бүрдүүлэхэд хувийн хэвшилүүдтэйгээ хамтарч ажиллана.



4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах.

4.1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аж ахуй эрхлэх, сурч боловсрох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.

4.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх боломж нөхцөлөөр хангах бодлого баримтална.

4.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг сайжруулахад эрүүл мэндийн байгууллагуудтай хамтарч ажиллана.

4.4 Төрийн болон олон нийтийн байгууллагуудын орц, гарцыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй байх боломжийг нэмэгдүүлнэ

5. Нийгмийн талаарх хэрэгжүүлэх бодлого

5.1 Эмнэлэг болон эрүүл мэндийн төвүүдийн үйлчилгээг сайжруулахад менежмент хийж ажиллана.

6517143980
ДЮА0052 9001034

5.2 Эмнэлгийн үйлчилгээ орчин нөхцлийг сайжруулахад анхаарна.

5.3 Эмнэлгийн ажилчдыг мэдлэгжүүлэх, чадваржуулахад бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.

5.4 Хүүхдүүдийн сурх орчин нөхцлийг сайжруулж, эрүүл аюулгүй орчинд сурч боловсрох нөхцлийг нь сайжруулна.

5.5 Багш нарийг чардавхижуулах ажлыг тогтмол зохион байгуулж, ажиллах орчныг сайжруулах, багш нарын эрхийг хамгаалахад хамтарч ажиллана.

